



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 03 дугаар сарын 09

№ 01176 ДУА-2018/8/СТА-ТТЗ

Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-г заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Цагаандэлгэр сумын Тусгай зориулалтын сангуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад Байгаль хамгаалах сангаас нийт сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан буюу анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 16,015,200.00 / арван зургаан сая арван таван мянга хоёр зуу / төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос гандан хийд засварлахад зориулан сангийн 15,000,000.00 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан
2. Сангаас 355,200.00 төгрөгийн хоолны үнэ шилжүүлж зориулалт бусаар зарцуулсан.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ дахь заалтууд, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 32.1 /тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно/ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.


3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу зарцуулалтын баримтгүй 660,000.00 төгрөгийн гүйлгээг санхүүгийн тайланд зардлаар тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажсаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх/ дэх заалтыг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих,

албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1 /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/, мөн журмын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Сангийн хөрөнгийг зориулалт бусаар хяналтгүй зарцуулсан, анхан шатны баримтыг хууль журмын дагуу бүрдүүлээгүй зэрэг зөрчлийг таслан зогсоох, цаашид дахин давтан гаргахгүй, холбогдох журмыг мөрдөж ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 04 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цагаандэлгэр сумын Засаг дарга Д.Буджав, нягтлан бодогч Т.Хүдэрчулуун нарт хариуцуулав.



АЛБАН ШААРДЛАГЫГ



¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/